

Сэргээн Засах Клиник Эмнэлэг

Уриа : "Танд бид эрүүл мэндийн чанартай үйлчилгээг хүргэнэ"

Байгууллагын үндсэн чиг үүрэг : Нийслэлийн хүн амд нөхөн сэргээх эрүүл мэндийн тусламж, эмчилгээ, оношлог оо, эрдэм шинжилгээ сургалтын цогц төрөлжсөн нарийн мэргэжлийн загвар эмнэлэг болно.

Зорилт:

1. Эмнэлгийн барилга байгууламжийг өргөтгөн, зориулалт бүхий барилга байгууламжтай болох үйлчлүүлэгчдэд тохитой нөхцөл бүрдүүлэх

2. Орчин үеийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээний аппарат, тоног төхөөрөмжөөр тоноглох

3. Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэн, мэргэжлийн өндөр зэрэгтэй боловсон хүчинтэй болох, эмчилгээ, үйлчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх

4. Нөхөн сэргээх эмчилгээний чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээний ажлыг явуулах бааз эмнэлэг болох

5. Эмнэлгийн гадаад харилцааг хөгжүүлэх

СЗКЭ-ийн товч түүх Түүхэн замнал

Сэргээн засах Клиник Эмнэлэг нь 1989 онд Монгол улсад үйл ажиллагаа явуулж байсан элэг цэсний архаг өвчтэй хүүхдийн сувилал, Эх нялхсын харьяа хүүхдийн сувилал, сульдаатай хүүхдийн сувиллыг нэгтгэн "Хүүхдийн сувилал" нэртэйгээр байгуулагдсан. Тус байгууллага нь байгуулагдахдаа мэс заслын дараах тасаг, захиргаа аж ахуйн гэсэн тасаг, дотор, бөөрний, мэдрэлийн, нөхөн сэргээх тасаг, захиргаа аж ахуйн гэсэн 6 тасгаас бүрдэж 8 их эмчтэй, ээлжийн 6 сувиллагч, ариутгагч, боловсон хүчин, эм найруулагч, дүн бүртгэлийн бага эмч, бусад ажилчид зэрэг 59 ажиллагсадтай хамт олноос бүрдэж үйл ажиллагаагаа үзүүлж байна.

Гол үзүүлж буй үйлчилгээ нь сульдаатай болон архаг өвчтэй 16 хүртэлх насны хүүхдэдээ асаргаа, сувилгаа, нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлж байна.

1993 онд Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр "Сэргээн Засах клиник эмнэлэг" болгон өөрчилж нийслэлийн нийт хүн амд нөхөн сэргээх тусламж үйлчилгээг үзүүлэх төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг болсон.

Нийгмийн салбарыг хувьчлах бодлогын хүрээнд 2004 оноос Сэргээн Засах Клиник Эмнэлгийг удирдлагын гэрээгээр удирдах тендерт Ц.Чанцал ахлагчтай удирдлагын баг амжилттай оролцон ажиллаж байна.

Одоо ажиллаж буй бүтэц: 1. Нөхөн сэргээх 1-р тасаг : Мэдрэл, тэс засал, гэмтэл, уламжлалт тасаг,

2. Нөхөн сэргээх 2-р тасаг: Үе мөч, зүрх судас
3. Нөхөн сэргээх 3-р тасаг: Бөөр, шээсний зам, амьсгал, хоол боловсруулах, бусад
4. Захиргаа аж ахуйн гэсэн нэгжийн зохион байгуулалттай

Боловсон хүчин: СЗКЭ нь нийт 61 эмч,ажиллагсадтай, Ерөнхий захирал 1, гүйцэтгэх захирал1, ерөнхий менежер 1, Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга 1, эмчилгээ чанарын менежер 1, эмнэлгийн ерөнхий зөвлөх 1, сургалт арга зүйн зөвлөх 1, их эмч 10, сувилагч 14 эмнэлгийн ажилчид 30 байна.